



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангуулах зайлшгүй шаардлагын хүрээнд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараах байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай.

1.1. Барилга байгууламжийн ажлын зураг төсөл, өртгийн төсөв, бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтыг холбогдох байгууллага албан тушаалтнаар батлуулж, аймгийн орон нутгийн өмчийн газарт 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө ирүүлэхийг сум, агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газарт;

1.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө, харьцуулалтын аргаар бараа, ажил худалдан авах болон зөвлөх үйлчилгээ сонгох аргаар хэрэгжүүлэх тендер шалгаруулалтын урилгыг 5 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө тус тус төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн байх, төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээллийг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс цахим системд оруулсан байх, бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчтэй байгуулах гэрээг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор баталгаажуулсан байхыг сумын Засаг дарга, Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлага, Орон нутгийн өмчийн газарт

2. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, 2023 онд төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-д, Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т тус тус даалгасугай.

2.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 онд аймгийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын хуваарийг хуулийн этгээд бүрээр батлан мөрдүүлж, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллах;

2.2. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын 2022, 2023 онуудын ажлын үр дүнг үнэлж, дүгнэхдээ тухайн хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэн тэргүүнд харгалзан үзэх;

d/zahiramj

6717010390


2.3. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл арга хэмжээг тусгахгүй байх;

2.4. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг дээшлүүлж, үр өгөөжийг өсгөх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг эрс нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.5. Орон нутгийн төсөвт байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах шаардлагагүй барилга байгууламжийн судалгааг гаргаж, тэдгээрийн барилгын ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал болон их засварын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх;

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН